

Эхлэл нь өмнөх дугаарт

## ОРЧИН ҮЕИЙН ТӨВ АЗИЙН МАЛ АЖ АХУЙ МАЛЫН ТУХАЙ АРДЫН УЛАМЖЛАЛТ МЭДЛЭГ

М.Хурметхан\*

### Товч утга

**Т**өв Азийн мал, мал аж ахуй, мал маллах арга технологи, ашиг шим орчин үеийн байдлыг тусган харуулсан.

**Түлхүүр үг:** төв ази, мал аж ахуй, орчин үе

Төв Азийн уугуул ард түмний аж төрөх ёсны бүрэлдэхүүн хэсэг нь тэдний этносоёлын ахуйн амин сүнс болсон таван хошуу малтай холбоотой ардын мэдлэг асар баялаг юм. Энэ нь олон зуун жилийн туршид байгалийн үзэгдэл, аж ахуйн явцыг гярхай ажиглах явцад үүсэн бий болж, бүрэлдэн тогтсон, тэгээд ёс заншил, технологийн ердийн туршлага болон бэхэжсэн туршлага, ажиглалт дүгнэлтийн нэгдсэн тогтолцоо билээ. Ардын эрдэм ухаан нь этносоёлын оюуны соёлын үндсэн элементийн нэг болохын хамтаар нүүдлийн нийгмийн үйлдвэрлэх хүчнүүдийн бүрэлдэхүүн хэсгүүдийг бүрдүүлэх нүүдлийн орчны үйлдвэрлэл-аж ахуйн явцын этносоёл болон технcлогийн удирдлагын зохион байгуулалтын хамгийн чухал хүчин зүйлийн нэг нь юм. Нүүдлийн нийгэмд хэрэглээний шаардлагын дагуу байгаль орчныг эзэмшихэд чиглэгдсэн тийм технологийн явцын нэг нь ардын мал эмнэлгийн ухаан юм. Энэ нь төв Азийн нүүдэлчин ард түмнүүдийн эрт дээр үеэс байгалийг эзэмшихэд холбогдсон туршлага, түүн дээр тулгуурлан бий болсон этносоёл, олон төрлийн үзэл суртал, нийгмийн харилцаа, эртний танин мэдэхүйн тогтолцоо билээ. Энэ нь аж ахуй болон ёс заншлын баримтлалтай нийлэн, зан заншилд шингэн, нүүдлийн соёл иргэншлийн өвөрмөц дүр төрхийг тодорхойлно.

Ардын мал эмнэлгийн ухаан нь тэдний нийгэм, эдийн засгийн эрх ашгийг хамгаалагч, мөн нийгмийн үйлдвэрлэх хүчний түвшинг

\*М. Хурметхан- Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D)

тодорхойлогч юм. Түүний үүрэг нь хүн ба мал бүхнийг өвчний аюулаас аврахын хамт, мал аж ахуй дахь эргэлтийн капиталыг, малаас хүнд дамжих өвчнөөс хамгаалах, нийгмийн эрүүл ахуйг хамгаалах явдал юм.

Ардын мал эмнэлгийн ухаанд малын бие болон эрхтнүүдийн бүтэцтэй холбоотой танин мэдэхүй чухал байр эзэлнэ. Тэд өөрийн тогтолцоо болон экологийн зохилдолгоороо өвөрмөц малын бие, морфологийн бүтэцтэй холбоотой ойлголт нь этносоёл дахь уламжлалт үеэс үед дамжуулах арга, мөн нийгмийн харилцаан дахь этикет нормуудыг хэрэгжүүлэхийн үндэс байдаг. Хоол хүнсний соёлд оролцогч хүмүүсийн нийгэм, нас, хүйс, стратегийн байдал хувь, зоог хуваарилахтай холбогдсон ёс заншлууд, малын анатоми /мах, яс гэх мэт/ холбогдох ойлголт болон ойлголтод үндэслэгдэнэ.

Өөрөөр хэлбэл, малын үе мөч, мах нь тодорхой нийгмийн агуулгын дагуу уламжлалт харилцааг зохицуулж байдаг уян хатан этносоёлынч “зэвсэг” байна. Тэгээд ёс заншлын нормууд, итгэл үнэмшлийн баримтлал нь малын анатомын уламжлалт танин мэдэхүйд тулгуурладаг юм. Тухайлбал, эмэгтэй хүүхдэд богтос, хүүхдүүдэд нойр булчирхай, өнчин элэг, өнчин уушгийг өгөхийг хориглоно.

Ёс мэдэхгүй явдал хүний нийгмийн нэр хүндэд нөлөөлөх тул ёс заншлыг хүн бүр малын анатомын сайн мэдэхийг эрмэлздэг байна. Малд анимист, ясанд фетишт шинж авхуулахаас үүсэн гардаг ясыг тахин шүтэх нь морфологийн мэдлэгт тулгуурласан байдаг юм. Ихэнх түрэг хэлтэн болон монголчуудад дайсны эсрэг үйл ажиллагаа хийх арга хэмжээ болох далыг галын дөлөнд барихад бий болох зурвасыг харж мэргэлэх болон түүний реминисция “дал харах”, өөрөөр хэлбэл морфологийн бүтцийг харж, таамаг хийх зэрэг ариун нандин үйл ажиллагааг явуулах нь тусгай мэдлэгтэй байхыг шаардана.

Казахууд далны хэлбэрийг харж, малын эзний ахуй амьдралын байдал, нийгэм болон байгалийн байдлыг таамаглана. Морфологийн мэдлэгийн өөр нэгэн жишээ нь малын насыг тодорхойлохоос харагдана. Малын шүдний хээ, эвэр, туурайн цагирагийг харж, насыг тодорхойлно. Тухайлбал 5-11 насандаа адууны шүд “дугуй мөртэй”, 12-18 насандаа зууван, 18-23 насандаа гурвалжин хэлбэртэй болно гэж үздэг нь морфологийн шинжлэх ухаанд 1807 онд Венанийн эрдэмтэн Пессинагийн нээлттэй адил байгаа нь казахуудын ардын мал эмнэлгийн томоохон ололтыг илтгэж байна. Таван хошуу малын зан авирыг танин мэдэж, түүнийг соёл аж ахуйн амьдралд хэрэглэн заншжээ. Этологи нь нүүдэлчдийг малын эрүүл мэндийг

хамгаалах, аж ахуй дахь хөдөлмөрийг хөнгөвчлөх болон сайн дадлыг малд хэвшүүлэхэд чиглэгдэнэ. Малчид аялга үгийг тодорхой хөгтэйгээр давтах, малд зохиомол рефлекс тулгуурласан төлөрхөй нэг хэвшилд дасгадаг. Энд казах, монгол, тувачуудын мал тойглохыг дурдаж болно. Малын этологид малын хэвийн биш хөдөлгөөнийг ажигласнаар малчид цаг уурыг урьдчилан таамагладаг юм. Малын зан авирыг нийгмийн шаардлагад зохицуулдаг билээ.

Малыг өвчлөлтөөс хамгаалахын тулд бэлчээр ажиглах, аж ахуйг зохион байгуулах гэх мэт арга туршлага чухал байр эзэлнэ. Малын өвчнөөс сэргийлэх нь нүүдэлчдийн байгалийг эзэмших, малын этологи, ардын зурхай, этноботаник, уламжлалт аж ахуйн мэдлэгийн нийлбэр юм. Төв Азийн нүүдэлчдийн ардын мал элнэлэгт нь малын өвчинг танин мэдэх, оношлох, эмчлэх практик, эмпирик арга хэмжээ чухал байдаг. Тэд малын өвчинг халдварт, халдваргүй гэж хуваан үздэг байна. Төв Азид халдварт өвчин бага тархсан бөгөөд энэ нь нүүдэлчид малын селекц болон урьдчилан сэргийлэх ажлыг зөв зохион байгуулдаг, байгаль цаг уурын нөхцөлтэй холбоотой юм. Төв Азид малд нэлээд тохиолдох хавдах, хордох шинжээр илрэх халдварт өвчин бол - элэгний хавдар, хүчиг тахал, догол, галзуу, шүлхий болно. Тэдгээрийг эмчлэхэд хавдрыг хагалах, халуун төмрөөр хайлах, давс цацах, хандаар угаах зэрэг түгээмэл аргуудыг хэрэглэнэ. Мөн мал тус бүрт тохиолдох өвчнийг ялган таньж, тохирсон эмчилгээг хийнэ. Төв Азийн нүүдэлчдийн дунд малын халдваргүй өвчнийг эмчлэх аргууд олон дэлгэрчээ. Энэ нь толгой, гэдэс, элэг, уушги болон төл, эх малын өвчин гэх мэт мөн яс хугарах, шарх гэх мэт өвчинг эмчлэх явдал юм. Тухайлбал, хивэгч малын тархинд уйланхай бий болбол, түүнийг галзуу гээд түүний үе шат бүрийг малын хөдөлгөөнийг ажиг мэдэж ялгадаг байна. Өвчний эхний шатанд уйланхай бүхий хэсгийг цог, халуун чулуу гэх мэт хайрч хорхойг "алах"-ыг оролдоно. Эцсийн шатанд толгойн ясны нимгэрсэн хэсгийг оточ нар арьсыг хутгаар зүсч, ясыг цоолоод, тархины гадаргуунд байх уйланхайг дэгээгээр татан гаргаж хаядаг. Зуд болох, өвс тэжээлийн хүрэлцээ муугийн улмаас малд ходоод - гэдэсний өвчин их тохиолддог юм. Тэднээс өргөн тархацтай нь гэдэс дүүрэх, чацага алдах гэх мэт байх бөгөөд тэдгээрийг эмчлэх аргууд нүүдэлчдийн дунд дэлгэрчээ. Мөн янз бүрийн шалтгаанаар малын яс хугарах, үе мултрах, шөрмөс сунах зэргийг эмчилнэ. Мал аж ахуйд мал төллөх үед зан заншил-цээрлэх ёс үйлчилдэг бөгөөд өвчин гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. Тухайлбал, мал төллөх үед хөрш айлд галын цог, тарагны хөрөнгө өгөхгүй, шагай

тоглохгүй, гэрт удаан босоогоор зогсохгүй, хүүхдийн үс авахгүй, нялх төлийн нурууг илэхгүй заншил байна. Мал хээл хаях, төл үхвэл хохирол зогсоох хүртэл нохойнхоо хүзүүнд хуцны хөг юм уу хөгний хэсгийг зүүнэ. Мал төллөх үед бий болох хүндрэлээс гарах, ардын малын эх барих туршлага өргөн дэлгэрчээ. Эх мал болон эцэг малтай холбоотой заншил нь өсч үржих ид шидтэй /магия/ холбоотой. Тэгээд эцэг мал тавих заншилд онцгой анхаарал хандуулна. Түүхэн хөгжлийн үе шат бүрт малын өвчин хийгээд түүний эсрэг арга хэмжээ шинэ загвараар баяжиж, танин мэдэхүйн хүрээ тэлжээ. Төв Азид XIX зууны сүүлээс мал эмнэлгийн орчин үеийн аргууд дэлгэрч эхэлсэн боловч орчин үед ч ардын мал эмнэлгийг хэрэглэх нь элбэг байна. Төв Азийн нүүдэлчдийн дунд мал эмчлэхээс эртний танин мэдэхүйд суурилсан магия, мистик арга, оточ, байгалийн заслаар эмчлэн, /эмийн ургамал, байгаль, ан амьтнаас авах эм бэлдмэлээр эмчлэн/ физик, хими, биологийн эм бэлдмэлээр эмчлэх билээ. Эмийн ургамал, амьтан, малын гаралтай эмийг мал эмнэлэгт өргөн хэрэглэнэ. Нүүдэлчдийн мал эмнэлэгт хэрэглэх эмийн төрөл, тоо маш олон, олон янзын бэлтгэх технологитой юм. Тэд ургамлын ургах үе шатыг нарийн ажиглан, хэрэгтэй үед нь цуглуулж, хатаан, эм бэлдмэл бэлдэж авдаг. Мөн нүүдэлчдийн дунд оточ болон тал эмчлэх багаж зэвсэг өргөн дэлгэрчээ. Оточ нар малын өвчнийг олон аргаар өөрсдийнхөө бэлтгэсэн олон төрлийн багажаар эмчилнэ.

Төв Азийн нүүдэлчдийн ардын мал эмнэлэг нь байгаль, гадаад ертөнцийг дэвшилттэй аргаар эзэмших болон олон зууны туршид бүрэлдэн тогтсон ардын ухааны бусад салбаруудтай нягт холбогдон хөгжсөн байна. Түүний салаа салбар бүр нь нүүдэлчдийн нийгэмд маш зохистойгоор, оюуны соёлын загварт аж ахуйн үйл ажиллагаа болон гоозүйн шаардлагад нийцэн бүрэлджээ. Түүний гол зорилго нь аж ахуйн тасралтгүй үйлдвэрлэх чадамжийг дээшлүүлэх явдал бөгөөд үргэлж өөрчлөгдөн хөгжиж, баяжиж байдаг амьдралд ойр практик ач холбогдолтой үйл явц билээ. Ардын мал эмнэлэг нь ямар ч архивгүй хадгалагдан, амнаас ам дамжин өвлөгддөг оюуны соёлын хэсэг болно. Нөгөө талаар ардын мал эмнэлгийн шинжлэх ухааны мал эмнэлэгтэй маш ойр дөт талууд бас олон бий. Тэгээд Төв Азийн нүүдэлчдийн оюуны соёлд ардын мал эмнэлэгтэй холбоотой ардын мэдлэг бие даасан суурь тогтолцоо болон бүрэлджээ. Тэр нь этносоёлын бүрэлдэхүүн хэсгийн хувьд нүүдлийн нийгэмд амьдралын бүх салаа мөчиртэй нягт холбогдсон үзэгдэл бөгөөд мөн нийгэм түүний дотор этносоёлын харилцааг зохицуулах болон байгалтай зохицон аж төрөх механизмын хуулиар үйлчилж иржээ.

### **Малын тухайт үгс**

Этологи нь нүүдэлчдийг мал аж ахуй дахь хөдөлмөрийг хөнгөвчлөх болон сайн далдыг малд хэвшүүлэх мэдлэг юм. Малчид аялга тухайт үгийг тодорхой хөгтэйгээр давтах, малд зохиомол рефлекс суулган малын зан авирыг захиран эдэлдэг бөгөөд тодорхой нэг хэвшилд дасгадаг. Монголчууд адууг “гуруй гуруй”, хонийг “.тфффу,тфффу”, ямааг “цүү, цүү, цүү, зүү, зүү, зүү”, үнээг “өөв өөв”, сарлагийг “хөөр хөөр”, тэмээг “дуур дуур төөр” гэж дуудна. Адууг тогтоон тайвшруулахад “хаая, хайя, хаа”, хонийг “дай дай, дая, чая чая”, саахад “хоолбай хоолбай”, ямааг “дай дай, дая дая, чая чая, чааг чааг”, хурга авахуулахад “тайга тайга” зэрэг юм. Казахад адууг кур -кур, куру -куру, үхрийг ау-хау, хонийг пушайт, пушайт, пүшай, пүшай, ямааг шөре- шөре, шөрей -шөрей, тэмээг көс көс, төл авахуулахад төйге-төйге гэх мэт болно.

### **Малын им тамга**

Төв Азийн нүүдэлчид эрт дээр үеэс малдаа им тамга хэрэглэж иржээ. Энэ нь гэр бүлийн онцлогийг бусдаас ялган салгасан тэмдэг юм. Малын чихний ар, өвөр, үзүүр талаас ухаж, хайчилж тэмдэглэснийг им, гуя, өгзөгт хайрч дарсан тэмдгийг тамга гэнэ. Им нь цуулбар, догол, онь, ухам, ганзага, сүйх, цоолбор гэх зэрэг олон янз юм. Казахын малын им нэрийг хүснэгтэд үзүүлэв.

Малын тамга олон янз бөгөөд ан амьтан, ургамал, тос, үсэг бичиг \түрэг, төвд, уйгур, кирилл\, хээ угалз,нар, сар гэх мэт болно. Тамгыг эзэн нь төмрөөр хийнэ.

Төв Азийн соёл иргэншил нь мал төвтэй нүүдлийн иргэншилд үндэслэн бий болж, бүрэлдэн хөгжиж өнөөдрийг хүрчээ. Тэдний эртний өвөг дээдэс малыг гаршуулан амь зууж, аж төрөх бололцоо олжээ. Ялангуяа адууг гаршуулан ашигласнаар орон зай, цаг хугацааг товчлон, орчин үеийн хэлээр бол санарын технологийнх шиг дэвшилд хөл тавьжээ. Тэгээд ч тэдний аюулгүй оршин тогтнох, улс төр эдийн засгийн гадаад харилцаа, материаллаг болон оюуны соёл нь мал аж ахуйд үндэслэн, тулгуурлан бүрэлдэн тогтжээ. Төв Азийн нүүдэлчдийн хувьд хамгийн амин чухал зүйл нь мал байсан бөгөөд өөрсдөөсөө илүү малынхаа аюулгүй байдлыг, түүгээрээ дамжин өөрсдөө эсэн мэнд оршин тогтнох бололцоог олж, хангаж иржээ. Тэгээд ч тэдний өдөр тутмын амьдралаас эхлэн улс төрийн амьдрал хүртэл малд үндэслэн бий болж, үргэлжилжээ. Тэгээд орчин үед Төв Азийн нүүдэлчдийн төлөөлөгчид нь ердийн боловсронгуй малчид хэвээр үлджээ.

Тэгэхдээ Төв Азийн нүүдэлчдийн соёл иргэншлийн үндэс мал аж ахуйг 20-р зуун шиг түйвээсэн түүх урьд нь гараагүй юм. Өнгөрсөн зуунд Төв Азийн нүүдэлчид өмнөх түүхийнхээ туршид хуримтлуулсан нандин өвөөс хагацаж байсны хамтаар зах зухаас эргэн олж авсан билээ.

Мал бол хүнээс байгалтай харьцах чухал механизм бөгөөд хүн түүгээр дамжуулан хэрэгцээт биоэнергийн гол хэсгийг олж авдаг юм. Мал бол өвсөн гэжээлтэн болон заяагдсан нь хүн төрөлхтөнд хосгүй боломж олгосон байна. Газарт өвс ургамал ургаж, түүнийг мал идэж, хосгүй үйлдвэрлэл явуулж, түүний үр дүнг хүн ашиглаж, газраас өөртөө хэрэгтэйг салгаж авдаг. Дэлхийн гадаргууд хүн байгаа цагт биоэнерги шаардагдах бөгөөд түүнийгээ газрын хөрснөөс малаар дамжуулан цэнэг авсаар байх болно. Энд нь Төв Азийн нүүдэлчдийн этносоёл чухал хэвээр байх болно.

### **Казахстаны мал аж ахуй**

Бүгд Найрамдах Казахстан улсын газар нутгийн хэмжээ 2727 Омян км.кв. Хойд талаараа ОХУ, өмнөд талаараа Киргизстан, Өзбекстан, зүүн талаараа БНХАУ-тай хил залгана. Казахстан нь НҮБ-ийн гишүүн 175 улсын дунд өөрийн газар нутгийн хэмжээгээр том газар нутагтай арван улсын дунд 9-р байранд орно. Хүн ам нь 16.716.524 хүн /2002/ Казакууд хүн амынхаа 60%-ийг эзэлнэ. Орос, Украин, Узбек гэх мэт бусад угсаатнууд аж төрнө. Казахстан бол байгалийн баялагаар асар баялаг нутаг. Газрын тос, байгалийн хий, ураны нөөцөөр дэлхийд нэлээн дээгүүрт орно. Хөгжлийнхөө хувьд дэлхийн тэргүүн хөгжилтэй 50 орны тоонд орох том зорилт тавьж байна. Казахстан бол томоохон мал аж ахуйн орон. Мал аж ахуйн үндсэн салбар нь хонин аж ахуй /мах, сүү/, үхэр, гахай, адуу, тэмээ, марал, шувуу, гэрийн туулай болно. Казахстаны мал аж ахуйн ерөнхий байдлыг дараагийн хүснэгтээс харж болно.

XX зууны эхэнд Казахстанд социализм байгуулах үл гүйцэлдэх үзэл нь мал аж ахуйг урьд хожид байгаагүй сүйрэлд хүргэв. Энэ нь хүн амын сүйрлийн үндэс болж, 1750 мянгаас 2200 мян хүнд өлсгөлөн, өвчний улмаас нас барсан байна. Хамтралжуулалтын явцад тус орны уугуул этносын 42-49% нь нас баржээ. Мөн 1 сая 30 мян хүн гадаадад дүрвэж, тэднээс 616 мян нь эргэж ирсэнгүй. Казахстаны түүхэнд хамтралжуулах явдал хамгийн их хэр толбо үлдээв.

## Орчин үеийн төв азийн мал аж ахуй

Казахстаны 1916-1980 оны мал аж ахуйн бүх салбарын малын тоо \мян.тол\ 1

Он	Үхэр	Хонь Ямаа	Гахай	Адуу	Тэмээ
1916	5062.1	18364.1	278	4340	
1928	9634.4	19169	252.7	3544	
1941	3355.9	8132	450.9	896.7	104.6
1951	4454.9	18038.2	400.4	1453.9	126.4
1961	5543.5	28718.3	1773.1	1158.2	140.5
1971	7285.5	31776.6	2265.7	1245.4	129.6
1977	7662.5	34464.4	2205.2	1296.2	124.3
1929	8013.4	34164	2842.8	1238.2	119.6
1980	8223.9	35024.6	3046.3	1254.3	122.3

Энэ нь нүүдэлчин казахуудыг хүчээр суурьшуулахаас эхлэв. Тэгээд 566 мянган нүүдэлчин ба хагас нүүдлийн гэр бүлийн 544 мянгыг нь суурин амьдралд шилжүүлэхийг төлөвлөв. 20-30-аад онд мал аж ахуйн талаарх коммунистуудын бодлого ихээхэн хувирамтгай байсан нь Казахстаны мал аж ахуйд хүндээр тусч байлаа. 1930 оны эхэнд хамтралжуулалтын хатуу журмыг бага зэрэг зөөлрүүлсэн боловч 1930 оны сүүлээр хөдөөгийн хүн амын 50.5%, 1931 оны үед 65%-ийг дахин хамтралд хүчээр нэгтгэжээ. 1928 онд 6 сая 509 мянган бод мал байсан бол 1932 онд 965 мянган толгой хүртэл хорогджээ<sup>3</sup>. Хонин толгой 18.5сая 943 мянгаас 1сая 386 мянга болтол хорогдсон байна.<sup>4</sup>

Үүний улмаас Бүгд найрамдах улсад хүнд байдал нүүрлэв. Хүмүүс өлсгөлөн болон өвчинд нэрвэгдэн, Сталины харгислал байдлыг улам хүндрүүлжээ. 1750000 хүн буюу казахуудын хүн амын 42% нь<sup>5</sup> 1932-33 оны өлсгөлөн, харгислалд өртөж, амь насаа алджээ. Казахын ард түмний эсрэг чиглэсэн өөр нэгэн арга хэмжээ бол славян гарлын хүмүүсийг нүүлгэн ирүүлж, суурьшуулах бодлого байлаа. 19-р зууны сүүл 20-р зуунд эрчимтэй явагдсан уг бодлогоор Казахстанд жил бүр 140000 –аас илүү хүн ирж, тавны нэг нь буцаж, үлдсэн нь байнга нутагшин үлдэж байв. Энэ бодлогыг зөвлөлт төр үргэлжлүүлэн хамтралжуулалтын явцад Казахстанд 220000 мал хөрөнгөө хураалгасан баячууд, дайнаас өмнө аж үйлдвэрийг барих гэсэн санаагаар 1200000 хүнийг нүүлгэн ирүүлжээ. Казахстанд шорон, лагерь барих зэргээр хүчээр суурьшуулах бүхэл бүтэн тогтолцоо бий болов. Дайны үед “урвасан” гэсэн шалтгаар Казахстанд Алс Дорнодоос 100000 солонгос, Ижил

мөрний 800000 герман, ЗХУ-ын баруун бүсээс 100000 гаруй польш, хойд Кавказын 500000 оршин суугчдыг хүчээр шилжүүлэн ирүүлж суурьшуулав. Энэ үед Казахстаны хүн ам нь 1.5сая хүнээр нэмэгджээ. Дайны үед янз бүрийн үйлдвэрийн хамтаар 350000 хүн мөн нүүлгэн иржээ. 60-аад он хүртэл хойд болон төв Казахстаны атар газрыг эзэмшүүлэхээр 2.5 сая хүн нэмэгдэн иржээ. Дайнаас хойших үед дахин 150000 хүн Казакстанд баригдах цэргийн байгууламж, түүний дотор Семейн цөмийн туршилтын талбай, Байконурын сансрын буудалд суурьшжээ.

Ийнхүү олон сая хүн нүүж ирж, малын бэлчээрийг ихээр хагалан, цэргийн зориулалтаар ашиглах болсон зэрэг нь Казахстаны нүүдлийн болон мал аж ахуйн хөгжилд нөхөж баршгүй хор хөнөөл учруулсан байна.

Бүгд Найрамдах Казакстан улс тусгаар тогтнолоо заласнаар мал аж ахуйг өөрөөр удирдах бололцоо бий болов. Гэхдээ тусгаар тогтнолын эхний жилүүдэд мал аж ахуйн байдал амаргүй байсныг хэлэх хэрэгтэй. Казахстаны нутгийн 70%-ийг бэлчээр эзэлдэг юм. 2001 он гэхэд 19.7 сая толгой тахиа, 8.4сая хонь /1980 онд 35024 мян толгой байсан/ 1.7 сая гахай, 976000 адуу, 1сая орчим ямаатай байв. 2001онд 667000 т мах үйлдвэрлэснээс 43% нь үхрийн мах, 14% нь хонины ба хурганы мах, 27% нь гахайн, 5% нь тахианы ба 11% нь бусад мах байв. Ноосны үйлдвэрлэл чухал байр эзэлдэг бөгөөд 2001 онд 23600 тонн ноос үйлдвэрлэв. Мөн онд 3923000 тонн сүү, 103000 тонн өндөг авчээ. Казакстанд 1996 оноос эхлэн малаас гарах ашиг шим нэмэгдэх хандлага ажиглагдах болжээ. Хөдөө аж ахуйг өөрчлөн байгуулах явцад хувийн сектор идэвхтэй хөгжжээ. 2001 оны эцэс гэхэд тус улсад 100000 гаруй хөдөө аж ахуйн байгууламж байсны 95000 нь тариачин, 2.3мян нөхөрлөл, 1.1 мян үйлдвэрлэлийн хоршоо, төрийн өмчид бүгд 79 үйлдвэр л үлджээ. <sup>6</sup>

Хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүн \бодит үнээр- 1994 он хүртэл- сая рубль, 1994 оноос -сая тенге\ /Мал аж ахуй/?

1991	1992	1993	1994	1995
5158	8347	8304	38307	84279
1996	1997	1998	1999	2000
101584	128875	144251	157267	178543
2001				
207869				



Хэдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлсэн шинэчлэлийн явцад мал аж ахуйн хувьд хэцүү төвөгтэй үе байв. Энэхүү байдалд ороход гол нөлөөлсөн зүйл бол 1991-1998 оны хооронд мал болон шувууны тоо толгой ихээхэн хорогдсонтой холбоотой байв. 1999-2001 оны хооронд мал аж ахуйд нааштай хандлага ажиглагдан 2001 онд 1998 онтой харьцуулахад үхэр 8.5%, хонь ямаа 10%, гахай 26%, шувуу 24% тус тус өгчээ.

### **Киргизстаны мал аж ахуй**

Киргизстан улс Дундад Азийн зүүн хойт хэсэгт оршдог. Нутаг дэвсгэрийн хэмжээ 198.5 мян.кв.км. Казахстан, Өзбекстан, Тажикстан, БНХАУ-тай хиллэнэ. Хүн ам нь 4822166 /2002/. Киргизстаны нутаг нь уулархаг, нутгийн 3\4-ийг өндөр уулс эзэлнэ. Газрын тос, байгалийн хийн орд бий. Нүүрсний нөөц нь 31 миллиард тонн бөгөөд Дундад Азид нэгдүгээр байранд ордог. Эх газрын ширүүн уур амьсгалтай, зун их бороогүй, халуун /+15-+53.6/, хур тунадасны хэмжээ 100-1000 мм. Усны нөөц сайн. 3000 гаруй нууртайгаас том нь Иссык нуур, Чатар нуур юм. Ургамлын төрлөөр асар баян. Тус улсад судалт ургамлын 3786 төрөл байх ба 3175 нь өвсний ургамал юм. Эмийн ургамал гэхэд 200 төрөл ургадаг нутаг болно. Тус улсад дэлхийн амьтны 3% нь байрлажээ. Хөдөө аж ахуйн 10547 га эдэлбэр газрын 9015 мян га буюу 86% нь байгалийн бэлчээр, 162 мян га /1.5%/ хадлангийн талбай эзэлнэ. Киргизийн ард түмэн байгаль цаг уурын нөхцөлд зохицсон мал аж ахуйг эрхэлсээр иржээ. Хөдөө аж ахуйгаас авах бүх бүтээгдэхүүний 43.8% нь мал аж ахуйд ноогдоно. Хүн амын хүнсний хэрэгцээ болон боловсруулах аж үйлдвэрийн хөгжил нь мал аж ахуйн хөгжилл түлхэц болжээ. Тэгээд ч өндөр үр ашигтайг мал үүлдэр угсааг гарган авсан бөгөөд үүнд хонины 3, үхрийн 2, ямааны 2, адууны 1 зэрэг юм. ЗХУ задарсны дараа бий болсон эдийн засгийн хямрал, нийгэм эдийн засгийн шилжилтийн үед мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл малын тоо толгой, ялангуяа, өндөр ашиг шимтэй малын тоо буурав. Хэрэв Киргизстанд 1990 онд 1205.2 мян толгой үхэр байсан бол 2003 онд 988.0 мян толгой, хонь ямаа 9900 мян толгой байсан бол 3800 мян толгой болж, гахай 312.6-87.2 мян толгой, шувуу 13914-3647.4 мян толгой болж буурчээ. Энэ хугацаанд зөвхөн адууны тоо толгой 312.6-360.7 мян толгой болж өсчээ. Мал аж ахуйн бүтээгдэхүүний өсөлт ажиглагдана. 2002 онд нядалгааны жингээр 201.1 мян тонн мах, 1172.9 мян тонн сүү, 243 сая ширхэг өндөг, 11.6 мян тонн ноос үйлдвэрлэсэн нь 1995 онтой харьцуулахад тооны бусад үзүүлэлт нэмэгджээ<sup>10</sup>.

	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001
Үхэр	9592.4	9576.3	9346.6	8072.9	6859.9	5424.6	4307.1	3957.9	3998.2	4106.6	4293.5
Үнээ	3490	3623.4	3687.2	3396.7	3045	2546.6	2109.6	1952.8	1962.3	2014.7	2077.2
Хонь ямаа	345555.7	34419.8	34208.1	25132.1	19583.9	13679.4	10384.3	9526.5	9656.7	9981.1	10478.6
Гахай	2976.1	2591	2445.2	1983.7	1622.7	1036.5	879	891.8	984.2	1076	1123.8
Адуу	1666.4	1703.5	1776.6	1636	1556.9	1310	1082.7	986.3	969.6	976	989.5
Тэмээ	145.1	148.8	154.8	141.2	130.5	111.2	97.1	95.8	9.1	98.2	103.8
Шувуу	59.9	52.7	49.8	32.7	20.8	15.4	16	17	18	19.7	21.1

—Казахстаны мал шувууны тоо \оны эцэс мян.тол\<sup>7</sup>

Казахстаны бүх салбарын мал, шувууны ашиг шим<sup>8</sup>

	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001
Нэг үнээнээс саасан сүүний дундаж кг	1934	1760	1767	1671	1642	1504	1558	1775	1913	1969	1992
Нэг тахианаас авсан өндөг ш	160	151	145	163	150	148	147	165	173	170	180
Нэг хониноос авсан ноосны жилийн дундаж кг	3	2.8	2.8	2.3	2.5	2.5	2.6	2.8	3	3	3
Үхрийн дундаж жин	341	314	317	275	278	267	280	289	327	319	293
Хонь ямаа	37	39	37	32	35	34	37	38	41	39	39
Гахай	102	90	94	86	80	84	94	94	103	98	101
Адуу	302	292	290	256	264	262	283	295	318	316	303

100 эхээс авсан төл	80	73	73	67	66	65	72	75	79	84	85
Тугал	92	86	92	78	83	86	92	92	95	96	98
Торой	979	848	820	876	858	881	756	845	844	992	1116
Унага	76	70	70	61	62	63	60	69	74	80	80

Казахстаны аж ахуйн бүх салбарын мал аж ахуйн үндсэн бүрэлдэхүүний үйлдвэрлэл<sup>9</sup>

	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001
Мах / нядалгаа- ны/	1524.4	1257.5	1311.5	1206.7	984.8	836.7	717.4	636.3	634.9	622.6	654.5
Сүү	5555.4	5265.1	5576.5	5296.0	4619.1	3627.1	3334.5	3364.3	3535.2	3730.2	392239
Өндөг /сая, ш/	4075.3	3564.7	3288.2	26.29.3	1840.8	1262.4	1265.8	138.4	1512.4	1692.2	1855.3
Арьс	101.4	96.4	94.6	75.3	58.3	42.2	34.6	25.2	22.3	22.9	23.6
Каракуль /мян,ш/	1821.4	1994.5	1879.3	1950.9	1145.2	1033.4	361.2	214.3	152.3	129.9	124.4
	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001
Мал аж ахуй	9158	8347	8304	38307	84229	101584	128875	144251	157267	178543	207869

Өөрчлөлт шинэчлэлтийн явцад хувийн өмчид тулгуурласан фермер, гэрийн, хоршооны, аж ахуй хөгжих болов. Улсын мэдэлд малын үнэт генофондын үржил селекцийн сектор үлджээ. Малын үүлдэр угсааг сайжруулах ажил үргэлжлэн хийгдэж байна. Тус улсад 17.3 мян толгой сарлаг байдаг бөгөөд тэднийг бусад малын бэлчээрт хор учруулахгүйгээр 250 мянгад хүргэж болно гэж үзэж байна. Киргизстаны бэлчээр нь адууны аж ахуйд гойд тохиоромжтой. Адууны мах шингэц сайтай. Өөх, А, В витамин, төмөр, кобальт, иод зэргээр баялаг тул адууны махны хэрэгцээ ихээхэн нэмэгджээ. Киргиз адууны генофонд чухал байдаг. Мөн адууны сорт хөгжсөн байна.

### **Монгол Улсын мал аж ахуй**

Монгол Улс Төв Азийн өндөрлөгт 1.5 сая ам дөрвөлжин нутаг эзлэн оршино. 2.5 сая хүн амтай, нийслэл нь Улаанбаатар хот 900 мян орчим хүнтэй. Тэнгис далайгаас алслагдсан болохоор уур амьсгал эрс тэс дөрвөн улиралтай, нутаг дэвсгэрийн хэмжээгээр дэлхийд 16-р байранд ордог бөгөөд жилд хур тунадас нь 400 мм хүртэлх хэмжээнд нутаг дэвсгэрийн зонхилох нь хамрагдана. Аж үйлдвэр, ХАА-н орон бөгөөд 2002 оны байдлаар ДНӨ-ийн 62%-ийг хот сууринд, 38%-ийг хөдөө орон нутагт үйлдвэрлэжээ. ХАА-н бүтээгдэхүүний 80%-ийг МАА, 20%-ийг газар тариалангийн салбарт үйлдвэрлэж байна.

Монгол улс уламжлалт мал аж ахуйн орон билээ. 1930-аад он гэхэд хүн амын 90%-ийг хамарсан хэсэгт малын 70%, үлдсэн 10%-д нь малын 30% нь төвлөрч байжээ. Тэгээд социализм байгуулах үл гүйцэлдэх үзлийн дагуу 1925 оноос феодал агсдын хөрөнгийг, юуны түрүүн малыг хурааж эхэлжээ. Өөрөөр хэлбэл, 100%-ийн хөрөнгө нь тэр үеийн ханшаар бол 3000 төгрөг, эсвэл 60 тэмээ, 100 адуу, эсвэл 100 үхэр, эсвэл 500 хоньтой тэнцэж байжээ. 1929-1930 онд 100 ба түүнээс илүү хөрөнгө бүхий 920 гаруй өрхийг хамарч, тэднээс 729 нь тухайн үеийн ханшаар 5.2 сая гаруй төгрөгийн үнэ бүхий мал ба үл хөдлөх хөрөнгө хураалгажээ. Эдгээрээс 1560436 төгрөг 70 мөнгөний үнэ бүхий зүйлүүдийг ядуу ардуудад шилжүүлэн өгснөөс гадна бусад мал хөрөнгийг 130 хамтралд хувааж өгчээ. 1931-32 онд хөрөнгө хуваах ажил дахин үргэлжилжээ. 1929 оны 9 сараас 1932 оны 2 сарын хооронд давхардсан тоогоор 1554 феодал, хувийн аж ахуйтнаас тухайн үеийн ханшаар 9722567 төгрөгийн хөрөнгө хураажээ. Энэ арга хэмжээ нь хүний эрхийг бүдүүлгээр зөрчсэн, түрэмгий ажиллагаа байсан бөгөөд мал сүргийн тоог өсгөх

идэвхийг эрс бууруулжээ. 1930-1937 онд улсын мал сүрэг 31.3%-иар буюу 23.6 саяас 16.2 сая болтлоо хорогдож<sup>11</sup>, ядуу ба огт малгүй аж ахуйтны тоо ч нэмэгджээ. Энэ нь зүүнтний адил балмад явуулгын уршиг, хувийн өмчийн үзэл санааг шууд боогдуулсантай холбоотой байв.

Шинэ эргэлтийн бодлого хэрэгжих явцад мал аж ахуйд зарим нааштай өөрчлөлт ажиглагджээ. Энэ ардын аж ахуйтны чухал санаачилгыг дээшлүүлэх, татварын бодлогод өөрчлөлт хийв. 1932 онд баталсан “БНМАУ-ын морин өртөөний албаны тухай хууль”-иар мал бүхий өрхийн бас нэг хүнд дарамт арилжээ. Ардын аж ахуйтанд улсаас мөнгөн зээл олгож, малын үүлдэр угсааг сайжруулах, дулаан хашаа саравч барих, худаг ус гаргахад чиглэгджээ. Эдгээр арга хэмжээний үр дүнд 1940 он болоход тус улсын нийт мал сүрэг 26204.8 мянга болж, 1932 оноос 39.1%-иар өсчээ<sup>12</sup>. 1939 оны эцэст нийт малтай өрхийн 43% нь дундчууд болж, тэд бүх малын 67.2%-ийг өмчилж байжээ. БНМАУ-ын 8-р их хурлаас ардын аж ахуйтныг хоршооллуулах анхны дэвсгэр болох ардын сайн дурын үйлдвэрийн нэгдлүүдийг хөгжүүлэх нь чухал гэж заажээ. I ба II таван жилийн явцад мал аж ахуйг хөгжүүлэхэд малчин ардын хувийн аж ахуйг улс нийгмийн өмч болгоход чиглэгдэв. Нэгдэлжүүлэх хөдөлгөөнийг хүчээр явуулснаар 1958 онд ардын аж ахуйтны 149,5 мян өрх буюу 75% нь хамрагджээ. 1959 оны сүүлч гэхэд мал аж ахуйг хоршоолж дуусгав. Мал аж ахуйд хоршоолол 1960-1991 оны хооронд оршин тогтсон билээ. Энэ үед мал аж ахуйд үйлдвэрийн чанартай барилга байгууламж, машин, тоног төхөөрөмж нэмэгдэв. Нийгмийн мал өсч улсад нийлүүлэх мах, сүүний хэмжээ өссөн ч малчдын амьдрал дээшилсэнгүй ч хөдөөгийн хөдөлмөрчдийн эрүүл мэнд, соёл, ахуй амьдралд өөрчлөлт гарсан юм. 1990 оноос улсын хэмжээний 255 нэгдэл, нэгдсэн дундын үйлдвэр, хоршоолол зэрэг нь мал, материаллаг бааз нь хувьчлагдав. Монголын мал аж ахуй улсын эдийн засгийн ноён нуруу бөгөөд 160000 хүн ажиллаж байна. Бэлчээр бол улсын бүх нутгийн 75 орчим хувийг эзэлнэ. 2001 он гэхэд тус улсад 13876000 хонь, 10269000 ямаа, 3097000 үхэр, 3200000 адуу, 352000 тэмээ, 21000 гахайтай байв. Ноолуурын үйлдвэрийн өсөлттэй холбогдон 1994\95 он гэхэд ямааны тоо толгой нэг саяар нэмэгдэв. Монгол Улсад адуу, тэмээ, сарлаг зэргийг спортын чиглэлээр өргөн ашиглаж байна. Монгол улсын малын тоо, мах, сүү, арьс ширний үйлдвэр

*М.Хурметхан*

Монгол орны малын тоо \мян.тол\<sup>13</sup>

Он	Бүгд	Малын төрөл				
		Тэмээ	Хонь	Үхэр	Хонь	Ямаа
1918	9645.6	228.7	1150.5	1078.4	5700.1	1487.9
1924	13776.1	275	1339.8	1512.1	8444.8	2204.4
1930	23676.2	780.9	1566.9	1887.3	15660.3	4080.8
1950	22702.2	844.2	2317	1987.8	12574.6	4978.6
1960	23000.5	859.1	2502.7	1905.5	12101.9	5631.3
1970	22574.9	633.5	2317.9	2107.8	13311.7	4204
1980	23771.4	591.5	1985.4	2397.1	14230.7	4566.7
2010	32729.5	269.6	1920.3	2176	14480.4	13883.2
2011	36335.8	280.1	2112.9	2339.7	15668.5	15934.6

Монгол орны мах үйлдвэрлэл \мян.тонн\

	Малын төрөл	Он		
		1990	2000	2011
1	Үхэр	2693	3097.6	2339.7
2	Адуу	2188	2660.7	2112.9
3	Тэмээ	558	322.7	280.1
4	Хонь	14265	13876	15668.5
5	Ямаа	4858	9591.3	15934.6

Төрөл	2008	2009	2010	2011
Жингээр	221.3	269.1	201.2	208
Үхэр	56.3	58.6	45.2	53.6
Хонь ямаа	119.9	168.9	127.5	124.3

	Сүүний төрөл	Он				
		1965	1970	1980	1990	2000
1	Үнээний сүү	128	130	160	271	368
2	Хонины сүү	55	51	14	16	20
3	Ямааны сүү	36	35	12	13	32

*Орчин үеийн төв азийн мал аж ахуй*

Монгол орны арьс шир бэлтгэл \ мян.тонн

	Малын төрөл	Он					
		1965	1970	1980	1990	2000	2010
1	Үхрийн шир	7.317	8.280	11.975	16.00	21.00	717.4
2	Хоньны арьс	9.093	10.285	14.329	34.00	25.00	6981.6
3	Ямааны арьс	2.325	2.500	3.092	6.00	9.00	6368.3
4	Угаа-гаагүй ноос	16.580	18.533	20.500	12.000	12.000	23.5
5	Ноолуур						6.3

Монгол Улсын статистик мэдээлэл, 2011 тт.202-235

Бэйжуулсан төл мал

Бойжуулсан төл мал	2008	2009	2010	2011
Бүгд	12780.0	13767.4	7399.2	12540.7
Ботго	40.5	40.1	36.4	42.3
Унага	377.5	420.8	274.0	429.1
Тугал	670.0	719.1	541.0	662.9
Хурга	6003.5	6549.4	3895.8	5887.9
Ишиг	5688.4	6038.0	2652.0	5518.5

Зүй бусаар хорогдсон том малын тоо \ мян.тол\

Төрөл	2008	2009	2010	2011
Бүгд	1640.6	1732.9	10319.9	651.3
Тэмээ	3.4	2.9	17.0	2.4
Адуу	122.0	62.9	369.7	27.6
Үхэр	132.9	107.1	581.0	52.9
Хонь	652.8	681.4	4363.8	284.0
Ямаа	729.4	878.5	4988.4	284.4

**ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ**

- <sup>1</sup> Khinayat Babahumar. Traditional Veterinary knowledge of Kazakhs. А.2001.р.14
  - <sup>2</sup> КСЭ.Казахской ССР.А.,1980. т.351
  - <sup>3</sup> Н.Назарбаев. Калин елим,казагим.А.,1998.б.69
  - <sup>4</sup> Мөн тэнд б.166
  - <sup>5</sup> Мөн тэнд б.166
  - <sup>6</sup> Мөн тэнд б.167
  - <sup>7</sup> Казахстан.1991-2001 годы.Астана.2002.с.184
  - <sup>8</sup> Мөн тэнд с.290
  - <sup>9</sup> Мөн тэнд с.293
  - <sup>10</sup> Мөн тэнд с.204
  - <sup>11</sup> А.С.Ажыбеков.Животноводства Киргизстана.с.1-13
  - <sup>12</sup> Монгол Улсын түүх Боть 5.УБ.,2006.т.176
  - <sup>13</sup> National Economy of the MPR. 1921-1981.UB. 1982.р.178
- Монгол Улсын статистик мэдээлэл,2011 тт.202-235

Үргэлжлэл бий...